

Хураангуй

- Газар тариалангийн үйлдвэрлэлийн дэмжих зорилгоор Таримал ургамлын үр, сортын тухай шинэ хуулийн төслийг боловсруулах
- Ургац өндөртэй, нутагшсан сорт бүтээх ажлыг дэмжих зорилгоор Сортыг хамгаалах тухай хуулийн төсөл боловсруулах
- Ургамлын шинэ сорт хамгаалах олон улсын холбоо (UPOV), Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) үрийн чанарын стандарт, зохицуулалтуудыг шинэ хуулийн төсөлд тусгах
- Үр үржүүлэг, сорт сорилтын салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, дэмжих

Монгол орны газар тариалангийн үйлдвэрлэлийн амжилтын үндэс - үр, сортын салбарын хөгжил

Газар тариалангийн үйлдвэрлэлийн амжилт нь таримал ургамлын үрийн чанараас шууд хамаардаг билээ. Иймд үрийн чанар нь стратегийн хувьд чухал ач холбогдолтой юм. Хүн амыг хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн, хүнсний ногоо, жимс жимсгэнээр хангахын тулд сайн чанарын үр тариаланчдад хүртээмжтэй байх нь чухал юм. Монгол орны байгаль цаг уурын нөхцөлд тохирсон, өвчин, хортонд тэсвэртэй, ургац арвинтай сортыг тариалах нь хүн амыг боловсруулах үнээр, тогтмол, чанар сайтай хүнсээр хангаж, улмаар хоол хүнсний хомсдол үүсэх эрсдэлийг бууруулна.


Монгол улсад үр, сортын салбар нь төрийн байгууллагуудын мэдэлд байна

Монгол улсад үр сортын салбар нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ) болон холбогдох бусад төрийн байгууллагуудын чиг үүрэгт багтдаг бөгөөд тэдгээр байгууллагуудаас шууд хамааралтай оршин тогтнож байна. Тухайлбал, Хөдөө аж ахуйг дэмжих сан нь импортын болон дотооддоо үйлдвэрлэсэн үрийг худалдан авч, тариалан эрхлэгчдэд эргэн төлөлтийн таатай нөхцөлтэйгөөр худалдан борлуулдаг бол Онцгой байдлын ерөнхий газар /ОБЕГ/ нь улаан буудайн үрийг стратегийн бүтээгдэхүүн гэсэн утгаар нь их хэмжээгээр улсын нөөцөд авдаг ба Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /МХЕГ/ нь үрийн чанарын хяналт, талбайн хянан баталгааг хариуцан ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн их сургуулийн /ХААИС/ харьяа Ургамал, газар тариалангийн хүрээлэн /УГТХ/ нь ургамлын шинэ сорт бүтээх, селекцийн ажлыг голлон хариуцдаг бол цөөн тооны тодорхой хэдэн аж ахуйн нэгжүүд үржүүлгийн материал болон үр үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна.

Implemented by





Үрийн дотоодын хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна

Үр сортын салбар нь хэдийгээр төр засгийн мэдэлд байдаг хэдий ч олон жилийн туршид тус салбар нь дотоодын хэрэгцээгээ хангаж чадахгүй хэвээр байна. Зах зээл дээр үрийн хомсдол их байдаг тул тариаланчид ургацынхаа тодорхой хэсгийг нөөцөлж, дараа жил нь тариалдаг явдал их байдаг. Энэ нь цаг хугацаа өнгөрөхийн хэрээр ургацын гарц, чанарт муугаар нөлөөлдөг байна. Гадны улс орнуудаас оруулж ирсэн импортын үр нь газар тариалангийн үйлдвэрлэлийг үр ашигтай эрхлэхэд шаардлагатай чанар, стандартыг тэр болгон хангадаггүй. Мөн үр сортын салбарын хууль эрх зүйн орчин, зохицуулалтууд бүрдээгүй, өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байгаа нь энэ салбарт үйл ажиллагаа явуулдаг иргэд, аж ахуйн нэгжүүдэд ихээхэн хүндрэл учруулж байна. Тухайлбал, тариаланч ямарваа нэгэн сортын үр худалдан авахдаа сортын онцлог, соёолох чадвар, цэвэр байдал зэрэг зайлшгүй анхааран ёстой үзүүлэлтүүдэд найдах ямар ч бололцоогүй болж байгаа юм.

Таримал ургамлын үр, сортын тухай хууль – үр сортын салбарын ирээдүй

“Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”, “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” зэрэг бодлогын баримт бичгүүдэд таримал ургамлын үр сортын салбарын ач холбогдлыг онцолсон байдаг бөгөөд сорт сорилт, үр үржүүлэг, таримал ургамлын олон янз байдлыг дэмжих замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ гэж тусгажээ. 1999 онд батлагдсан Үр сортын тухай хууль нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байгаа төдийгүй сортын хамгаалалт, бүртгэлжүүлэлт, үр үйлдвэрлэл, үр худалдан борлуулахтай холбоотой олон улсын дүрэм журмуудад мөн нийцэхгүй байна. Таримал ургамлын үр сортын салбарын тогтолцоог шинэчилсэнээр газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх нөхцөл бүрдэхээс гадна хүнсний алдагдал, хаягдлыг бууруулахад шууд бусаар нөлөөлөх юм.

Таримал ургамлын үр, сортын тухай хуулийг шинэчлэн баталсанаар үр, сортын салбарыг үндэсний хэмжээнд хөгжүүлэх нөхцөл бүрдэх бөгөөд таримлын шинэ сортыг бүртгэх, хамгаалах, хамгаалагдсан сортын үрийг үржүүлэх, хянан баталгаажуулах, үрийн сав баглаа боодол, шошго, үрийн худалдаа зэрэг асуудлуудыг цогцоор нь шийдэх боломж бүрдэнэ.



Таримал ургамлын үр, сортын тухай шинэ хууль – тариаланчдыг чанартай үрээр хангах боломж

Нутагшсан сорт, сайн чанарын үр нь бүтээмж өндөртэй газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх амжилтын үндэс билээ. Иймд тариаланчид төрөл бүрийн сортын чанартай үрээс сонголтоо хийдэг, чанартай үрийн хангамж, хүртээмж сайн байх нь нэн чухал юм. Зах зээл дээр худалдан борлуулж буй үрийн чанарыг хараад шууд мэдэх боломжгүй тул таримал ургамлын хууль эрх зүйн орчны хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллагаар баталгаажсан байх зайлшгүй шаардлагатай. Таримал ургамлын, үр сортын тухай хуулийн гол зорилго нь тариаланчдыг бүртгэгдсэн сортын баталгаажсан үрээр хангаж, чанар муутай үрийн худалдааг хязгаарлах явдал юм.

Таримал ургамлын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгосноор үр үржүүлгийн явцад **сортын шинж чанар, үрийн чанарын үзүүлэлтүүдийг хянаж**, шинжилхээс гадна үр боловсруулах, сав баглаа боодол, шошголох зэрэг үр үйлдвэрлэлийн бүхий л үйл явцыг хянах, зохицуулах боломжтой болно.

Олон улсад сорт сорилтын дүнд тулгуурлан өөрийн шинж чанараараа шалгарсан **сортыг сортын бүртгэлд бүртгэж авдаг**. Тухайлбал, Ургамлын шинэ сорт хамгаалах олон улсын холбооны (UPOV) конвенцид сорт нь ялгагдахуйц, жигд, тогтвортой байх ёстой (DUS) гэж заажээ. Мөн хөдөө аж ахуйн таримлуудад үнэт чанарын сорилт (VCU) хийдэг бөгөөд энэ нь ургац, үрийн чанар, эрсдэл даах тэсвэр ба технологийн үзүүлэлтүүдийг соридог байна. Тухайн таримал нь төрөл бүрийн агро-экологийн нөхцөлд хэрхэн ургах чадвартай байгааг сорих үүднээс үнэт чанарын сорилтыг өөр өөр туршилтын талбайд хийж гүйцэтгэдэг байна.

Үрийн чанарын стандартыг мөн тусгайлан журамлах бөгөөд үрийн чанарыг баталгаажуулахдаа ургамал ургах явцад талбайн хянан баталгааг зайлшгүй хийдэг. Хянан баталгаажсан үрийг худалдан борлуулахдаа талбайн хянан баталгаа хийгдсэн тухай дүгнэлт болон үрийн генетекийн чанар, соёолох ба амьдрах чадвар зэргийг шинжилсэн лабораторын шинжилгээний бичгийг баталгаа болгон дагалдуулж өгдөг. Хянан баталгаажсан үрийг хангалттай хэмжээгээр, боломжийн үнээр үйлдвэрлэснээр тариалангийн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлж, зах зээл дээрх хүнсний хүртээмжийг сайжруулах боломжтой болно.

Үрийн зах зээл дээрх **хяналтын механизм** нь Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулж, тариаланчдын эрх, ашгийг хамгаална.

Үрийн хянан баталгаажуулалтыг нэгдсэн арга зүйгээр хийх нь хөрш зэргэлдээ орнуудтай төдийгүй бусад гуравдагч улс орнуудтай үрийн худалдаа хийх боломжийг бүрдүүлнэ. Тухайлбал, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) үрийн зохицуулалтуудад нийцсэн арга зүйг мөрдөх нь өндөр чанарын үрийг импортлох, экспортлох боломжийг нэмэгдүүлдэг байна. Иймд Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн төсөл боловсруулахдаа олон улсад мөрдөгддөг стандарт, журмуудыг харгалзаж үзэх нь зүйтэй юм.

Чанартай үр, сорт, түүний ач холбогдлын талаар **тариаланчдыг тогтмол мэдлэгжүүлж**, сургах нь тариалангийн үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй.

Сорт бүтээгчид, тариалачдад “Сортыг хамгаалах тухай хууль”¹-ийн ашиг шимийг хэрхэн хүртэх боломжтой вэ

Монгол орны уур амьсгал, хөрсний бүтэц нь хөдөө аж ахуй, ялангуяа газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэхэд ихээхэн хүндрэл учруулдаг билээ. Эх газрын эрс тэс, хуурай уур

¹ ХБНГУ-ын “Сортыг хамгаалах тухай хууль” буюу олон улсад “Plant Breeders Right”

амьсгалаас шалтгаалан Монгол оронд тариалалтын улирал богино байдаг тул байгаль цаг уурын энэхүү хүнд хэцүү нөхцөлд дасан зохицсон, тэсвэртэй сортуудыг тариалах шаардлага тулгардаг.



Эх сурвалж: Герман-монголын хамтын ажиллагааны Тогтвортой хөдөө аж ахуй төсөл

Ургац алдах эрсдэлийг багасгаж, хүн амын хүнсний хангажмийг тогтвортой байлгах зорилгоор таримал ургамлын сортыг бүтээгч нь аль болох

- Өндөр ургацтай
- Өвчин хортонд тэсвэртэй
- Абиотик стресс тэсвэрлэх чадвартай
- Шим тэжээлийн бодисын агууламж, хадгалалт даах чадвар зэрэг технологийн үзүүлэлтүүд сайтай
- Хүнсний бус зориулалтаар ашиглагддаг таримал, тухайлбал эрчим хүч үйлдвэрлэхэд ашигладаг таримлын сортыг шинээр бүтээхийг зорьдог тул сорт бүтээгчдийн хөдөө аж ахуйн салбарт оруулж буй хувь нэмэр асар өндөр юм.

Сорт бүтээгчдийн оюуны өмчийг хамгаалах шаардлагатай

Нэг шинэ сортыг бүтээхэд урт хугацааны, өндөр зардалтай маш нарийн судалгаа шинжилгээний ажлууд хийгддэг бөгөөд дунджаар 12-15 жил шаардагддаг байна. Харин нэгэнт шинээр гаргаж авсан сортыг үржүүлэхэд хурдан, хялбар байдаг тул сорт бүтээгчдийн оюуны өмчийг зайлшгүй хамгаалах хэрэгтэй. Сорт бүтээгчийн эрхийг хамгаалснаар сорт бүтээгч нь роялти хуримтлуулах боломжтой бөгөөд, ийнхүү тэрээр хөрөнгө оруулалтаа нөхөж, дараа дараагийн эрдэм шинжилгээний ажлуудаа санхүүжүүлэх боломжтой болдог. Сорт бүтээгчийн эрх авснаар тухайн хамгаалагдсан сортыг үржүүлэх, зах зээлд гаргах давуу эрх үүсдэг. Энэ нь сорт бүтээх явцад гаргасан хөрөнгө оруулалтаа нөхөх, урт хугацаанд ашгаа өгдөг тул сорт сорилтын салбарынханд томоохон хөшүүрэг болдог байна. Сорт бүтээгчийн эрхийг хамгаалах хууль нь сорт бүтээгч төдийгүй тариаланчдад дараах давуу талыг бий болгож байна:



- Сорт бүтээгчдэд үүсэх давуу тал
Патентаас ялгаатай нь хамгаалагдсан сортыг ямар ч сорт бүтээгч өөрийн селекцийн ажилдаа ашиглах боломжтой юм. Энэхүү “нээлттэй эх үүсвэр” нь сорт бүтээх ажилд томоохон түлхэц өгдөг.
- Тариаланчдад үүсэх давуу эрх
Хамгаалагдсан сортын үрийг тариаланч өөрийн хэрэгцээнд дахин тариалах боломжтой юм. Өөрөөр хэлбэл хамгаалагдсан сортын үрийг худалдаж авсан тариаланч, тухайн үрийг өөрийн хэрэгцээнд зориулан үржүүлэх эрхтэй болно.

Энэхүү сорт бүтээгчийн эрх нь ихэнхдээ 25 жил байдаг ба сорт бүтээгчийн эрх дууссан тохиодолд, тухайн сортын үрийг ямар нэгэн роялти төлөхгүйгээр худалдан борлуулж, үржүүлэх боломжтой болдог.

Сортыг хамгаалах тухай хуулийн үр нөлөөг хэмжих нь

Дэлхийн олон улс орнууд сорт хамгааллын энэхүү системийн нэвтрүүлсэний дараагаар үр нөлөөг нь хэмжиж үзэхэд сорт бүтээх, селекцийн ажлууд нэмэгдэж үр дүнд нь шинэ сортууд ихээр төрөн гарчээ (UPOV, 2005/ HFFA, 2017).

Сорт бүтээгчийн эрхийг хамгаалсан одоогийн хүчин төгөлдөр байгаа хууль нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг сорт бүтээх ажилд оролцох оролцоог нэмэгдүүлсэн бөгөөд энэ нь эргээд өрсөлдөөнийг бий болгосноор тариаланчид илүү сайн, чанартай үрээр тариалалт хийх боломжийг нэмэгдүүлжээ. Улмаар маркетинг, борлуулалтын сүлжээ сайжирч, эцсийн хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлсэн байна. Хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш гадны улс орнуудаас оруулж ирэх сортын нэр төрөл олширч, тариаланчдад сонголт нэмэгдсэн байна. Мөн сорт бүтээгчид импортын сортуудыг өөрийн селекцийн ажилд авч ашигласнаар дотоодын сорт бүтээх, селекцийн ажлыг дэмжих боломж бүрдэнэ. Сорт бүтээгчийн эрхийг хуулиар хамгаалах замаар үр, сортын салбарыг дэмжих нь улмаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ахиц авчран, эцсийн хэрэглэгчдэд давуу талыг бий болгосон байна. Сорт бүтээгчийн эрхийг хамгаалах асуудлыг Сортыг хамгаалах тухай хуульд оруулснаар үр нөлөө нь улс орны эдийн засагт сайнаар нөлөөлсөн байна.

Дүгнэлт:

- Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн зорилго нь үр, сортын салбарыг хөгжүүлэх таатай орчинг бүрдүүлэх явдал юм. Энэ нь тариаланчид, үр үйлдвэрлэгчдэд төдийгүй хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний эцсийн хэрэглэгчдэд ашиг тусаа өгөх юм.
- Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн төслийг боловсруулахдаа Ургамлын шинэ сорт хамгаалах олон улсын холбооны (UPOV) дүрэм, журмууд, зарчимүүдыг баримтлах нь зүйтэй ба ингэснээр Монгол улс тус холбооны гишүүнээр элсэхэд дөхөмтэй болно.
- Олон улсад мөрдөгддөг холбогдох стандарт, дүрэм журмуудад хуулийн төслөө нийцүүлсэнээр тариаланчдад хүрэх үрийн чанар дээшлэх, улмаар дотоодын үрийг экспортлох боломж нэмэгдэнэ.
- Үр, сортын салбар хөгжихийн хэрээр Төр засгаас сортын бүртгэл, талбайн хянан баталгаа, үрийн чанарын хяналт зэрэг тодорхой ажлуудад анхаарлаа хандуулах хэрэгтэй.
- Засгийн газраас аль болох хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлсэн, инновацийг дэмжсэн, генетикийн нөөцийг ашиглах боломжийг нээсэн бодлогууд баримтлах нь зүйтэй юм.



- Эдгээр хууль эрх зүйн баримт бичгүүдийг амжилттай хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг бүхий л түвшинд шаардлагатай. Ялангуяа, талбайн хянан баталгаа, үрийн лаборатори, үр сортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудыг чадавхижуулах нь нэн чухал юм.

Ашигласан хэвлэл:

2nd World Seed Conference: Responding to the challenges of a changing world: The role of new plant varieties and high-quality seed in agriculture, 2009

Food and Agriculture Organization of the United Nations (FAO): Voluntary Guide for National Seed Policy Formulation, 2015

HFFA Research GmbH (corresponding author: Steffen Noleppa): The socio-economic benefits of UPOV membership in Viet Nam: An ex-post assessment on plant breeding and agricultural productivity after ten years, 2017

International Union for the Protection of New Varieties of Plants (UPOV): International Convention for the Protection of new Varieties of Plants, 1991

International Union for the Protection of New Varieties of Plants (UPOV): UPOV Report on the impact of Plant variety protection, 2005

Organization for Economic Co-operation and Development: OECD Seed Schemes; OECD Schemes for the Varietal Certification or the Control of Seed moving in International Trade, 2017

Зохиогчид:

Фрийдхилде Траутвайн,
Холбооны сортын агентлаг
Реферат П1

Др. Алфред Катер,
Герман-Монголын хамтын ажиллагааны Тогтвортой
хөдөө аж ахуй төслийн удирдагч
a.kather@iagleipzig.de

Тайлбар: Энэхүү бодлогын зөвлөмжид багтсан баримт, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогч хариуцна. Уг зөвлөмж нь Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” (MNG 16-01) төслийг санхүүжүүлэгч Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.